



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 10 дугаар сарын 05 өдөр

Дугаар 87

Хэрлэн сум

LXXXVII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 87 дугаар хуралдаан 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 10:00 цагт танхимаар 85,1 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдлын мэдээллийг танилцуулах,

Эрүүл мэндийн газар

2.Коронавируст халдвар /Ковид-19/-аар өвчилсөн жирэмсэн эх, бага насны хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрхэн хүргэж байгаа талаар мэдээлэл танилцуулах,

*Эрүүл мэндийн газар,
Бүсийн оношлогоо эмчилгээний төв*

3.Үхрийн арьс товруутах өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

4.Ой, хээрийн түймрийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

5.Аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабын иргэдээс хүсэлт хүлээн авах 70580119 дугаар ашиглалтын талаар мэдээлэл танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар


6.Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдалд хяналт тавих ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулах,


Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

Цагдаагийн газар,

Тагнуулын газар,

Мэргэжлийн хяналтын газар,

/  / М.Бадамсүрэн

/  / х/а Г.Нармандах

7.Аймгийн Онцгой комисст аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг танилцуулах,
-Иргэн Ц.Ойдовжав
-Хатан хэрлэнгийн долгио

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад эрсдэлтэй бүлгийн жирэмсэн эх, 0-12 насны хүүхдүүдийг хамруулах ажлыг зохион байгуулах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн Ш.Ёл,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

1.2.Коронавируст халдвар /Ковид-19/-аар өвчилсөн иргэдийг хэвтүүлэн эмчлэх ор нэмэлтээр дэлгэх талаар судалж, саналыг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулах,



Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

1.3.Хүйтний улирал эхэлж коронавируст халдвар /Ковид-19/ илрүүлэх шинжилгээний цэгийг нүүлгэсэнтэй холбогдуулан мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах,

1.4.Эх баригч эмчээр ажиллах эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах, коронавируст халдвар /Ковид-19/-аар өвчилсөн жирэмсэн эхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байгаа талаар мэдээллийг бэлтгэж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Хил хамгаалах байгууллагын дарга,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.1.Хилийн бүсэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх цурав татах ажлыг зохион байгуулах,

 / М.Бадамсүрэн
 /х/а Г.Нармандах

Баян-Уул, Баяндун, Дашбалбар сумын Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

2.2.Хилийн бүсэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх цурав татах ажилд хүн хүч, анжис трактор, ус тээвэрлэх тээврийн хэрэгслээр хангаж ажиллах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Хилийн анги, салбарын дарга захирагч нарт:

2.3.Хилийн бүсэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх цурав татах ажилд хилийн хамгаалах байгууллагуудтай хамтарч ажиллах,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-т:

2.4.Хилийн бүсэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх цурав татах ажилд шаардлагатай ус тээвэрлэх тээврийн хэрэгслийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэх,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Аймгийн Шуурхай штабын иргэдээс хүсэлт хүлээн авах 70580119 дугаарт "Call pro" үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах телефон утас худалдан авах 110,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгох,


Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

3.2.Аймгийн Шуурхай штабын иргэдээс хүсэлт хүлээн авах 70580119 дугаарыг Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвд, 70583366 дугаарыг Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн шуурхай штабт байршуулж ажиллах,

Дөрөв.АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

4.1.Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд коронавируст халдвар /Ковид-19/-тай холбоотой санхүүгийн асуудал хариуцсан багийг томилж ажиллуулах,

4.2.2021 оны сумдын төсөвт батлагдсан хөрөнгө оруулалтын хөтөлбөр арга хэмжээнээс хэрэгжих боломжгүй болсон арга хэмжээний зардлыг "Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуульд заасан эрх хэмжээний хүрээнд Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг тэмцэх урсгал

 / М.Бадамсүрэн
/ Г.Нармандах

үйл ажиллагааны зардалд шилжүүлэх боломжийн талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нартай цахим хурал зохион байгуулж зөвлөмж өгөх,

4.3.Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр томилогдон нэмэлтээр ажиллаж буй албан хаагч нарт урамшуулал олгох талаар санал боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-т:

4.4.Хэрлэн сумын багийн хэсгийн ахлагч нарт халдвар хамгааллын хувцас хэрэгсэл болон бусад талаар дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Ө.Бат-Өлзий-д:

4.5.Хэрлэн сумын 11 багийн ажлын албаны Коронавируст халдвар /Ковид-19/-аар өвчилсөн, гэрээр эмчлэгдэж буй иргэдэд хяналт тавих ажилд нэмэлтээр ажиллах төрийн байгууллагуудын албан хаагч нарын хуваарийг батлуулах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
гишүүн Ш.Ёл,
АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Э.Эрдэнэбилэг нарт:

4.6.Коронавируст халдвар /Ковид-19/-т өвчлөн гэрээр эмчлэгдэж буй төрийн байгууллагуудын албан хаагч нарт хяналт тавих ажлыг хариуцаж зохион байгуулах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат,
АЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Баяржаргал нарт:


4.7.Коронавируст халдвар /Ковид-19/-ын өвчлөн гэрээр эмчлэгдэж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын албан хаагч нарт хяналт тавих ажлыг хариуцаж зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

4.8.Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн "Гэрээр эмчлэх тусламж, үйлчилгээний эмийн багц"-д нэмэлтээр олгох антибиотик худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах,

4.9.Коронавируст халдвар /Ковид-19/-аар өвчлөөд эдгэрсэн тухай эмнэлгийн магадлагааг иргэдэд олгох, өвчилсөн иргэдийн тусгаарлалт, хяналтаас гаргах тухай Эрүүл мэндийн сайдын 2021 оны 549 дүгээр тушаалыг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

 / М.Бадамсүрэн
/ х/а Г.Нармандах

Тав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

5.1.Иргэн Ц.Ойдовжаваас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Үйл ажиллагааг эхлүүлэх тухай" хүсэлтийн дагуу ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн "Roller skate" байгууллагатай хариуцлагын гэрээ байгуулж, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэхэд хяналт тавьж, үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.2."Хатан хэрлэнгийн долгио" ТББ-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Нийтийн бүжиг зохион байгуулах тухай" хүсэлтийг хэлэлцэж аймгийн Онцгой комиссын 2021 оны "Нийтийг хамарсан арга хэмжээг хориглох тухай" 112 дугаар тогтоолын дагуу үйл ажиллагааг хориглох тухай хариу мэдэгдэхийг тус тус үүрэг болгов.

ДАРГА  М.БАДАМСҮРЭН

ОРЛОГЧ ДАРГА,
ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ

